



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, Төсвийн тухай хуулийн 6.2.3, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журмын 10.8, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.11.2, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025-2026 оны хичээлийн жилд мөрдөх бакалаврын сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг нэгдүгээр хавсралтаар тогтоон мөрдсүгэй.


2. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд явагдах бусад төрлийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг хоёрдугаар хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

3. 2025-2026 оны хичээлийн жилд шинээр элссэн оюутны мэргэшүүлэх хичээлийн нэг кредитийн үнэлгээг тооцохдоо ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээг 15 хувиар нэмэгдүүлэн тогтоосугай.

4. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тооцохдоо энэхүү тогтоолын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтад заагдсан сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг 1.5 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

5. Нэг кредитийн үнэлгээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт хийх тодотголын төслийг 2025 оны 11 дугаар сарын 15-ны дотор Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлэхийг ректор (Т.Намнан)-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.



367010010

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20
ны өдрийн 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ШУТИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилд мөрдөх бакалаврын
сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ /төгрөгөөр/

№	Сургууль	2025-2026 оны хичээлийн жилд шинээр элсэгч	2024-2025, 2023-2024 оны оны хичээлийн жилд элссэн оюутан		2022-2023 оны хичээлийн жилд элссэн оюутан		2021-2022 оны хичээлийн жилд элссэн ба түүнээс өмнө элссэн оюутан	
		Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Мэргэшүүлэх хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Мэргэшүүлэх хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Мэргэшүүлэх хичээлийн 1 кредитийн үнэлгээ
1	Барилга, архитектурын сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
2	Гадаад хэлний сургууль	185,600.0	148,000.0	170,200.0	141,000.0	162,150.0	108,000.0	124,200.0
3	Геологи, уул уурхайн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
4	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
5	Менежментийн сургууль	185,600.0	166,000.0	190,900.0	157,000.0	180,550.0	120,000.0	138,000.0
6	Механик инженер, тээврийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
8	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	185,600.0	166,000.0	190,900.0	157,000.0	180,550.0	120,000.0	138,000.0
9	Хүнс, хөнгөн, үйлдвэрлэл, дизайны сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	190,000.0	148,000.0	170,200.0	141,000.0	162,150.0	108,000.0	124,200.0
11	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
Дундаж		162,812.0						

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20
 ны өдрийн 05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ШУТИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилд явагдах
 бусад төрлийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ /төгрөгөөр/

Сургалтын төрөл	Нэг кредитийн үнэлгээ
Бямбын, эчнээ, гарагийн сургалт	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн нэг кредитийн үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тооцно.
Гадаад хэл дээрх хөтөлбөр, гадаад хэл дээр заагдаж буй хичээл /монгол оюутан/	
Магистрын хөтөлбөр	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор үржүүлж тооцно.
Докторын хөтөлбөр	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн нэг кредитийн үнэлгээг 1.8 коэффициентоор үржүүлж тооцно.
Ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн магистрын хөтөлбөр	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн инженер, технологийн бакалаврын хөтөлбөрийн сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор үржүүлж тооцно.
Ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн докторын хөтөлбөр	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн инженер, технологийн бакалаврын хөтөлбөрийн сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.8 коэффициентоор үржүүлж тооцно.